



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 17 өдөр

Дугаар A/11

Баянхутаг сум


Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол улсын Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн бага ангийн багш Б. Шижиртуяа нь Хэнтий аймгийн нийт бага ангийн багш нарын дунд зохиогдсон монгол хэл, бичгийн аймгийн олимпиадад сургуулиасаа шалгаран амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн тул уг амжилтыг үндэслэн үндсэн цалингийн 20%-иар тооцож ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Б. Шижиртуяад олгох ур чадварын нэмэгдлийг 6 дугаар сарын цалингаас бодож олгохыг нягтлан бодогч /Н.Ууганнавч/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Г. ГАНБОЛД